

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН  
ДЭРГЭДЭХ ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№

2023 оны 03 сарын 23

Налайх дүүрэг

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2023 оны 05 сарын 24-ны өдрийн 14:30 цагт эхлэж, 15:00 минутад дуусгав.

Хуралд: Зөвлөлийн дарга  
Нарийн бичгийн дарга  
Гишүүд:  
Нярав

Н.Пүрэвсүрэн  
Э.Энгүүн  
Г.Ганцэцэг  
Э.Ундармаа нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1. Худалдан авалтын шийдвэр гаргалттай холбоотойгоор

СОНССОН НЬ: Н.Пүрэвсүрэн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанаар газрын дарга нарт өгсөн үүрэг даалгаврын хүрээнд өнөөдөр хуралдах гэж байна. Цаг бүртгэлийн системд бүх байгууллага хамрагдсан байх ёстой гэсэн үүрэг даалгаврыг 2022 онд өгсөн байдаг. Гэтэл цаг бүртгэлийн системд бүртгэлгүй байгаа цөөн хэдэн байгууллагын нэг нь манайх гээд нэр цохогдсон байна. Энэ асуудал яагаад бүтэн жил шийдэгдээгүй байгаа вэ?

Э.Энгүүн: Тухайн үедээ хурууны хээгээр таньдаг систем ашиглахыг хориглоно гэсэн шийдвэр ирсэн. Тус шийдвэр ирэх үед манай байгууллагын хувьд Мобикомын сүлжээний улмаас цаг бүртгэлийн систем ашиглах боломжгүй, ашигладаггүй байсан, харин одоо дахин нэг тодруулж үзэх нь зөв байх.

Г.Ганцэцэг: Би цаг бүртгэлийн системийн үнэ ханш судлая аа. Энгүүн Мобикомын инженертэй холбогдоод, манайд ашиглах боломжтой эсэхийг тодруулчих.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 2023 оны 4-р сардаа багтаан цаг бүртгэлийн систем суурилуулж, ашиглалтад оруулах

ХЯНАСАН:  
КОМИССЫН ДАРГА  
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ПҮРЭВСҮРЭН

Э.ЭНГҮҮН